

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ /2021 оны 2 дугаар улирлын байдлаар/

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагад 2021 оны 2 дугаар улиралд иргэдээс нийт 9779 өргөдөл, гомдол, санал ирүүлсэн байна. Үүнээс өргөдөл 8864 буюу 90.6 хувь, гомдол 335 буюу 3.4 хувь, санал 580 буюу 5.9 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт 9779 өргөдөл, гомдол, санал ирсэний 9444 буюу 96.5 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, 1122 буюу 11.4 хувь нь бусад байгууллагад шилжүүлж, 335 буюу 3.4 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

2021 оны 2 дугаар улиралд аймгийн Засаг даргад хандаж тусламж хүсч өргөдөл ирүүлсэн 33 иргэнд 13.8 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүллээ.

Аймгийн онцгой комиссын тусгай дугаарын 7032-2855 утсанд 2 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор нийт 15683 иргэн хандсан байна. Үүнээс 9550 буюу 60.8 хувь нь хорио цээрийн дэглэм, орох гарах замын хөдөлгөөний талаар, 5430 буюу 34.6 хувь нь вакцинжуулалт, түүнтэй холбоотой мэдээлэл, 703 буюу 4.4 хувь нь коронавируст халдвар /ковид-19/-тай холбогдон гарсан шийдвэр, түүнтэй холбоотой мэдээллийг аваад байна.

Мөн орон нутгийн телевиз, *Өвөрхангай-“Ковид-19” нэгдсэн мэдээлэл гурпп, аймгийн Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар дамжуулан* коронавируст халдварын талаарх бодит мэдээллийг хүргэн ажиллаж байна.

Хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

СУМЫН ЗАСАГ ДАРГА, АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРТ

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 11 дүгээр тэмдэглэлд:

2021 оны 2 дугаар улирлын “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт”-ийн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Н.Энхцэцэг гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан сумын Засаг дарга, агентлагийн дарга нарт даалгав.

1. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг танилцуулгын хамт ирүүлж байх

2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу өгч, шийдвэрлэлтийг байгууллага болон иргэдэд ил тод мэдээлэх.

3. Улирал, хагас, бүтэн жилийн тайлан, мэдээг тухайн сум, агентлагийн дарга нарын гарын үсгээр албажуулж, аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх гэжээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2021.06.28

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт /Хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хугацаа болоогүй	
1.	Аймгийн ЗДТГазар	157	143	64	0	14	91.0
2.	Агентлагууд	960	857	18	18	103	89.2
3.	Сумд	7960	7774	338	2	186	97.6
4.	Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв /70321111/	702	670	702	32	32	95.4
Дүн		9779	9444	1122	52	335	96.5

--oOo--

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ /ХЭЛБЭРЭЭР/

2021.06.28

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Үүнээс:				
			Бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Бусад
1.	Аймгийн ЗДТГазар	157	157	-	-	-	-
2.	Агентлагууд	960	925	7	18	10	-
3.	Сумд	7960	6716	370	308	481	85
4.	Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв /70321111/	702	5	-	697	-	-
Дүн		9779	7803	377	1023	491	85
Хувь		100%	79.8%	3.8%	10.4%	5.0%	0.8

--oOo--

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/

2021.06.28

Арвайхээр

Аймгийн нэр	/тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
Өвөрхангай аймаг	Нийт өргөдөл, гомдол, санал 9779 ирсэн байна.	хүсэлт	8864	90.6%
		гомдол	335	3.4%
		санал	580	5.9%
	Нийгмийн халамжийн үйлчилгээ	2342	23.9%	
	Иргэний бүртгэл, мэдээлэл	1125	11.5%	
	Газар эзэмших, өмчлөх, шилжүүлэх	894	9.1%	
	Ажилд орох, чөлөөлүүлэх	700	7.1%	
	Тэтгэвэр тогтоолгох, тэтгэмж хүссэн	472	4.8%	
	Хөдөлмөр эрхлэлт	202	2.0%	
Материал, мөнгөн тусламж хүссэн	89	0.9%		
- Аймгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70321111 дугаарын утсанд нийт 702 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэнээс 670 буюу 95.4 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна.				